



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/222

Улаанбаатар хот

“Бурхан багшийн их дүйчин” өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/767 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн аялал жуулчлалын газрын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Бурхан багшийн их дүйчин өдөр” шашин, соёлын арга хэмжээг Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

3. “Бурхан багшийн их дүйчин өдөр” шашин, соёлын арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас хууль, журамд нийцүүлэн гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

